

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 20 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУДЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9 дэх хэсэг, АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АПУ ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.
2. АПУ ХК-ийн Дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай.
 - 2.1. 2-р зүйлийн 2.1 дэх хэсэгт “Хэрэглэгчийн сэтгэлд тохирсон, хүнсний аюулгүй байдлыг хангасан хамгийн сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэж ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн” гэж заасныг хасах;
 - 2.2. 2-р зүйлийн 2.2 дах хэсгийг доорх байдлаар өөрчлөх; “2.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл нь дараах байна:
 - 2.2.1. Архины үйлдвэрлэл;
 - 2.2.2. Шар айрагны үйлдвэрлэл;
 - 2.2.3. Спиртийн үйлдвэрлэл;
 - 2.2.4. Ундаа, ус, жүүсны үйлдвэрлэл;
 - 2.2.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
 - 2.2.6. Бөөний болон жижиглэн худалдаа;
 - 2.2.7. Гадаад худалдаа;
 - 2.2.8. Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах үйл ажиллагаа;
 - 2.2.9. Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
 - 2.2.10. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
 - 2.3. 7-р зүйлийн 7.22.17 (ТУЗ-ийн бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;
 - 7.22.17. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, эрх олгох;

- 2.4. 7-р зүйлийн 7.37 (Гүйцэтгэх захирлын бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;
7.37. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлүүлэх асуудлын төслийг боловсруулж шийдвэрлүүлэх, зөвшөөрөл авах;
- 2.5. 7-р зүйлийн 7.35 (Гүйцэтгэх захирал) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;
7.35. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж болно. Харин компанийн охин болон хараат компаниас бусад өөр аж ахуйн нэгж, өрсөлдөгч хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.
- 2.6. 8-р зүйлийн 8.1 (Компанийн эрх бүхий албан тушаалтан) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;
1.1. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Чиглэл хариуцсан захирлууд нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.
3. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлт орсноос бусад зүйл заалтууд хэвээр үлдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийг тусгасан Дүрмийг хавсралтаар баталж, түүнийг улсын бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөнө.
4. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасгай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБИЛЭГ

МОНГОЛ УЛС
APU COMPANY
Absolute. Pure. Unique.
АПУ ХУВЬЦААТ-КОМПАНИ
2702873 ☎ 1116224357

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн
02 тоот тогтоолын хавсралт



Хувьцаа эзэмшигчдийн
2012 оны 04 дүгээр сарын 27-ны
өдрийн хурлын шийдвэрээр шинэчилсэн найруулгыг батлав.

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ **/шинэчилсэн найруулга/**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Компани нь нээлттэй Хувьцаат компани болно.
- 1.3. Компанийн оноосон нэр нь:
Монголоор “АПУ” Хувьцаат компани
Англиар “APU” Joint stock company
Байршил нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
Хаяг нь: Монгол Улс, Улаанбаатар-36, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-14, Өөрийн байр
- 1.4. Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.5. Компани Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар хараат болон охин компани байгуулж болно.
- 1.6. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.7. Компани өөрийн бэлэгдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байна.
- 1.8. Компанийн бэлэгдэл, барааны тэмдгийг хэрэглэх эрхийг зөвхөн “АПУ” хувьцаат компани эдэлнэ.

Хоёр. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл

- ~~2.1. Хэрэглэгчийн сэтгэлд тохирсон, хүнсний аюулгүй байдлыг хангасан хамгийн сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэж ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.~~

Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр хассан.

- 2.1. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь:
- 2.1.1. Архины үйлдвэрлэл;
 - 2.1.2. Шар айрагны үйлдвэрлэл;
 - 2.1.3. Спиртийн үйлдвэрлэл;
 - 2.1.4. Ундаа, ус, жүүсны үйлдвэрлэл;
 - 2.1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
 - 2.1.6. Бөөний болон жижиглэн худалдаа;
 - 2.1.7. Гадаад худалдаа;
 - 2.1.8. Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах үйл ажиллагаа;
 - 2.1.9. Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
 - 2.1.10. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 2.2. Энэ зүйлд дурьдаагүй бусад үйл ажиллагаа эрхлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 2.3. Компани Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлж ажиллана.

Гурав. Хувь нийлүүлсэн хөрөнгө

- 3.1. ~~Компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ 1 төгрөг байх ба нийт 74,287,700 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.~~
~~Компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ 10 мөнгө байх ба нийт 742,877,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.~~
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчилсөн.
Компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ 10 мөнгө байх ба нийт 1,064,181,553 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
Энэ хэсгийг 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 тоот шийдвэрээр өөрчилсөн.
- 3.2. Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.3. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага

- 4.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

- 4.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцаа эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшлийн, саналын эрхтэй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 4.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
- 4.4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээнэ.
- 4.5. Компани тодорхой нөхцлөөр хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.
- 4.6. Дүрмийн 4.5-д заасан асуудал болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлуудыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.7. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон Төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно. Ийнхүү санал хүргүүлэх Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3-д заасан нөхцөлийг хангасан саналыг хүргүүлнэ.
- 4.8. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй. Ингэхдээ Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4-д заасан шаардлага хангасан мэдэгдлийг бичгээр гаргана.
- 4.9. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг жилд нэг удаа тодорхой үндэслэл бүхий шаардлага гарган хийлгэх эрхтэй. Ийнхүү шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч шаардлагын дагуу шалгалт хийсэн аудитын зардлыг хариуцна.
- Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 4.10. Компанийн энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг

- хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дундажаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй.
- 4.11. Компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлд санал, шаардлага гаргах эрхтэй. Ийнхүү санал, шаардлага гаргаж байгаа Хувьцаа эзэмшигч нь санал, шаардлагаа бичгээр гаргах бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3-д заасан нөхцөлийг хангасан байна.
 - 4.12. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
 - 4.13. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
 - 4.14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувьцаа эзэмшигч, дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшдэг бөгөөд түүний буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.
 - 4.15. Энэхүү дүрэмд тусгагдаагүй хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг хариуцлагын харилцааг “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, холбогдох зохицуулагч байгууллага болон “Монголын хөрөнгийн бирж”-ийн журмуудаар зохицуулах бөгөөд хууль, журамд нэмэлт өөрчлөлт орох тухай бүрт хувьцаа эзэмшигчдийн эрхийг хянаж, нэмэлт өөрчлөлтийг оруулна. Хэрэв компанийн дүрэм нь дээрх хууль, журамтай харшлах, зөрчилдөх тохиолдол гарвал компани нь хууль журамд нийцүүлэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхийг эдэлнэ гэдгийг хувьцаа эзэмшигч бүр зөвшөөрнө. Энэ тохиолдолд компани дээрх нэмэлт өөрчлөлтийн талаар мэдэгдлийг бүх хувьцаа эзэмшигчдэд 14 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ.

Тав. Компани үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн авах

- 5.1. Компани гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас /опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас/ гаргаж болно.
- 5.2. Компани зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 5.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.
- 5.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3 жил хүртэлх хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Өөрийн хөрөнгийн дүнг тухайн улирлын тайлан тэнцэлд тусгагдсан дүнгээр тодорхойлно. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт гаргах өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, зориулалт,

- хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заасан байна.
- 5.5. Компанийн өөрийн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3-аас дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.6. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдан авч болох энгийн хувьцаа нь компанийн гаргасан нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс их бол Хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо, нэгж опцион эзэмшигчийн худалдах болон худалдан авч болох хувьцааны тоо, үнэ, опционы хүчинтэй байх хугацаа зэргийг заасан байна. Опционд заасан хувьцааны үнэ нь опционыг гаргах өдрөөс өмнөх тухайн хувьцааны сүүлийн нэг сарын арилжааны жигнэсэн дундаж үнээс доогуур байж болохгүй.
- 5.7. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
- 5.8. Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.
- 5.9. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөр нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр байж болно. Үнэлгээг тогтоохдоо Төлөөлөн удирдах зөвлөл нь итгэмжлэгдсэн мэргэжлийн үнэлгээчин, үнэлгээний пүүс, компаниар гүйцэтгүүлэх ба үнэлгээг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон энэ талаар мөрдөгдөж буй олон улсын бусад стандартуудыг баримтлан гүйцэтгэсэн байна.
- 5.10. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дундажийн 25%-иас хэтэрч болохгүй.
- 5.11. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 53.2-д зааснаас бусад тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.
- 5.12. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно.

Зургаа. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа бүртгэл тайлан, ногдол ашгийн хуваарилалт

- 6.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

- 6.2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүү, нягтлан бодох бүртгэл хөтөлж холбогдох тайланг татвар, санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.
- 6.3. Компани Монгол Улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж байна. Компани гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.
- 6.4. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.
 - 6.4.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
 - 6.4.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх,
 - 6.4.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх,
- 6.5. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэдээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 6.6. Ногдол ашиг хуваарилаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл энэ тухай шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 6.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх захирал боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталж мөрдөнө.

Долоо. Компанийн удирдлага

А. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 7.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.
- 7.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заасан байна.
- 7.5. Шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар ээлжит бус хурлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.

- 7.6. Дор дурьдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 7.6.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, буюу дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах,
 - 7.6.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах,
 - 7.6.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох
 - 7.6.4. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох,
 - 7.6.5. Хувьцааг хуваах, нэгтгэх,
 - 7.6.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
 - 7.6.7. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг Хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх,
 - 7.6.8. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 - 7.6.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах,
 - 7.6.10. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас илүү хувийг буцаан худалдаж авахыг зөвшөөрөх,
 - 7.6.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд
- 7.7. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоог Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.
- 7.8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах 7.6.1-7.6.6-д заасан асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн дийлэнх олонхийн саналаар, дүрэмд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.9. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох эрхтэй гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу явуулна.
- 7.10. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэн даруй хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.
- 7.11. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонхийг эзэмшиж байгаа Хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Энд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлож энэ тухай протокол үйлдэн Төлөөлөн удирдах

зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.

- 7.12. Саналын эрхийн олонхийг эзэмшиж байгаа Хувьцаа эзэмшигчид оролцоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 7.13. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 7.14. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.
- 7.15. Хойшлогдсон хурал ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлаж хурал хүчин төгөлдөр болох ирцийг 7.11-д зааснаар тогтооно.
- 7.16. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр Хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Харин ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорхи асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно.
 - 7.16.1. Компанийн дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах,
 - 7.16.2. Компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх,
- 7.17. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комиссын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох эрхтэй.
- 7.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

Б. Төлөөлөн удирдах зөвлөл

- 7.19. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх хэмжээнийхээ дагуу улирал бүр хуралдаж шийдвэр гаргана.
- 7.20. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба үүний 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.
- 7.21. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8, 79.1-д заасан шалгуурыг хангасан байна.
- 7.22. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 7.22.1. Энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох,
 - 7.22.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх,

- 7.22.3. Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа нэмж гаргах,
- 7.22.4. Нэмж гаргах хувьцаа нь их хэмжээний хэлцэлд хамаарах бол хувьцаа нэмж гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтэй шийдвэрлэнэ. Санал нэгтэй шийдвэрлэж чадаагүй бол Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- 7.22.5. Энгийн хувьцааг худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион гаргах шийдвэр гаргах, түүнтэй холбоотой журмыг батлах
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.22.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох,
- 7.22.7. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 хүртэл хувийг болон бусад үнэт цаасыг худалдах, эргүүлэн авах,
- 7.22.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал, гишүүдийн цалин, урамшууллын нийт хэмжээг батлах,
- 7.22.9. Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох,
- 7.22.10. Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох,
- 7.22.11. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх аудитын байгууллагыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.22.12. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах,
- 7.22.13. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох,
- 7.22.14. Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах,
- 7.22.15. Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, хөрөнгө оруулалт хийх замаар охин болон хараат компани байгуулах, шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг эдлэх
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.22.16. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийн төслийг бэлтгэх, шийдвэрийг хэрэгжүүлэх,

- 7.22.17. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичиг¹-т заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, эрх олгох;
Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.22.18. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох,
- 7.22.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны гишүүдийг томилж тэдгээрийн эрх үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах,
- 7.22.20. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал,
- 7.23. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийг ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
- 7.24. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, эсхүл нас барсан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс түр томилно.
- 7.25. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.
- 7.26. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг, гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 7.27. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос сонгоно.
- 7.28. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих зэрэг Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 7.29. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.30. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 7.31. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд биеэр оролцох боломжгүй тохиолдолд интернэт эсвэл утсан харилцааг ашиглан хуралд оролцож хэлэлцэх асуудлаар санал өгөх болонэчнээ санал хураалтаар санал өгч шийдвэр гаргаж болно.

¹ АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор баталсан Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичгийг ойлгоно.

- 7.32. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-д заасан тайланг бэлтгэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

В. Гүйцэтгэх захирал

- 7.33. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 7.34. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно.
- 7.35. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж болно. Харин компанийн охин болон хараат компаниас бусад өөр аж ахуйн нэгж, өрсөлдөгч хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.
Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.36. Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заана.
- 7.37. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичиг²-т заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлүүлэх асуудлын төслийг боловсруулж шийдвэрлүүлэх, зөвшөөрөл авах;
Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 7.38. Компанийн эрх бүхий албан тушаалтныг ажилд томилох, чөлөөлөх, компанийн орон тоо, цалингийн сангийн хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлөөр тогтоолгох, компанийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулах ба цуцлах зэрэг компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

Найм. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

- 8.1. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Чиглэл хариуцсан захирлууд нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.
Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан.
- 8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлагын болон бусад холбогдох эрх зүйн асуудлыг Компанийн тухай хуулийн 84, 85-р зүйлд заасны дагуу зохицуулна.

² АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор баталсан Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичгийг ойлгоно.

- 8.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад өгөх ба уг жагсаалтанд өөрчлөлт орсон тухай бүр уг мэдээллийг компанид мэдэгдэнэ. Энэхүү жагсаалт гаргах зааврыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 8.4. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь авилгын эсрэг журам, түүнийг хэрэгжүүлэх горимыг хүлээн зөвшөөрсөн гэрээг компанитай байгуулах ба компанийг төлөөлж Гүйцэтгэх захирал гарын үсэг зурна. Авилгын эсрэг журам, түүнийг хэрэгжүүлэх горимыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

А. Аудитын хяналт

Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчилсөн

- 9.1. Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас сонгосон эрх бүхий аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.
- 9.2. Энэ дүрмийн 9.1-д заасан гэрээг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах бөгөөд гэрээнд аудитын эрх үүрэг, хариуцлага, аудитын байгууллагад төлөх хөлсний хэмжээг заана.
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан
- 9.3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан
- 9.4. Ээлжит бус шалгалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдийд ч хийж болно. Аль нэг Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн Хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл Хувьцаа эзэмшигч компани, Хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- 9.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудитын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй.

- Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан
- 9.6. Дараах этгээдийг компанийн аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно.

Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 тоот шийдвэрээр өөрчлөн найруулсан

- 9.6.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан,
- 9.6.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу хөрөнгийн эрх эзэмшдэг бол,
- 9.6.3. Аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар гэрээ хэлцэл хийсэн бол.

Арав. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

А. Аудитын хороо

- 10.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах чиглэлээр дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:
- 10.1.1. Санхүүгийн тайлан санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих,
- 10.1.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод хяналт тавих, зөвлөх,
- 10.1.3. Хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлогод хяналт тавих, зөвлөх
- 10.1.4. Компанийн дотоод аудитын нэгжийн удирдлага, ажилтныг томилох санал боловсруулах, тэдгээрийн цалин урамшууллын хэмжээг тогтоох санал боловсруулах,
- 10.1.5. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал өгөх,
- 10.1.6. Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах,
- 10.1.7. Төлөөлөн удирдах зөвлөлөөс даалгасны дагуу тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах,
- 10.2. Аудитын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа танилцуулна.

Б. Нэр дэвшүүлэх хороо

- 10.3. Нэр дэвшүүлэх хороо 3 гишүүнтэй байх бөгөөд дор дурьдсан асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах шийдвэр гаргах бүрэн эрхтэй:

- 10.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 10.3.2. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 10.3.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- 10.3.4. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 10.3.5. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 10.3.6. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 10.3.7. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах

В. Цалин, урамшууллын хороо

- 10.4. Цалин, урамшууллын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:
 - 10.4.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 10.4.2. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
 - 10.4.3. компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

Арван нэг. Компанийг татан буулгах

- 11.1. Компанийг дараахи тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.
 - 11.1.1. Дор дурдсан нөхцөл байдал бий болсон, эсхүл дараах нөхцөл байдал удаан хугацаагаар үргэлжилж байгааг харгалзан Хувьцаа

эзэмшигч аль нэг талын гаргасан саналыг авч хэлэлцээд санал нэгтэй шийдвэр гаргасан:

- a) Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон,
 - b) Компанийг татан буулгахыг Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи зөвшөөрсөн,
 - c) Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи нь компанийг хуваах, өөр компанид нэгтгэх шийдвэр гаргасан,
- 11.2. Монгол улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана.
- 11.2.1. Дампуурсан,
 - 11.2.2. Нэг ч гишүүн үлдээгүй,
 - 11.2.3. Хуульд заасан бусад үндэслэл,
- 11.3. Татан буулгах шийдвэр гаргасан гишүүдийн хурлаас татан буулгах комиссыг томилно. Төлөөлөн удирдах зөвлөл татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг Хувьцаа эзэмшигчдэд хувиарлах журам зэргийг тусгасан татан буулгах төсөл, хуваах эсхүл нэгтгэх шийдвэр гарсан бол хуваах болон нэгтгэх төслийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 11.4. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно.
- 11.5. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.
- 11.6. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчдэд мэдээлнэ. Нэхэмжлэл гарах хугацаа нь татан буулгах тухайг нийтэд мэдээлснээс хойш 3 сар байна.
- 11.7. Татан буулгах, шийдвэр гаргах үед компани ямар нэг өргүй байвал компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлээгүй байж болно.
- 11.8. Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг гишүүдийн хурал батална.
- 11.9. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.
- 11.10. Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлөөр компанийн бусад эд хөрөнгийг худалдаж болно. Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө эсхүл тэдгээрийг худалдаж борлуулсан орлогыг Хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.

- 11.11. Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.
- 11.12. Компани нэгдэх, өөрчлөн зохион байгуулснаас үйл ажиллагаа нь дуусгавар болж байгаа тохиолдолд бүртгэх байгууллага болон олон нийт, зээлдүүлэгчдэд хүргэх мэдэгдэлд компанийн эрх үүргийг шилжүүлж авсан хуулийн этгээдийн нэрсийг заана. Хуваагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон бол хуваах балансны дагуу компанийн эрх, үүргийг шилжүүлж авсан хуулийн этгээд тус бүрийн нэрсийг мэдээлнэ.
- 11.13. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

Арван хоёр. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 12.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, бүртгэх байгууллагад бүртгүүлснээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.

_____ООО_____

Хувьцаа эзэмшигчдийн
2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн
хурлын шийдвэрээр оруулсан
нэмэлт өөрчлөлтийг тусгав.

Хувьцаа эзэмшигчдийн
2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн
хурлын шийдвэрээр оруулсан
нэмэлт өөрчлөлтийг тусгав.

Хувьцаа эзэмшигчдийн
2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн
хурлын шийдвэрээр оруулсан
нэмэлт өөрчлөлтийг тусгав.